# ДУНДГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛИЙН ТАЙЛАН

2019.12.31

**Нэг. Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх талаар зохион байгуулсан ажил:**

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд иргэдээс амаар, бичгээр болон цахим сүлжээ, утсаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэж өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд тавих дотоодын хяналтыг сайжруулан хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Байгууллагаас гаргасан олон нийтэд хамааралтай дүрэм, журам, санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах утас, хаягийг мэдээллийн самбарт болон байгууллагын цахим хаягт байршуулж, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэхэд анхаарч ажиллалаа.

Тус байгууллагад хандаж иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд Албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэн улирал тутам явцын хяналт хийж дүгнэлтийг байгууллагын хамт олны хурал дээр танилцуулдаг.

Иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдолд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйл “Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ.”-ийн дагуу шийдвэрлэн ажиллаж байна. Дээрх мэдээллийг байгууллагын цахим хуудас www.dundgovi.gazar.gov.mn/-ны үйл ажиллагааны ил тод байдал хэсэгт байршуулсан.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын хариуг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 133 дугаар тушаалын 08 дугаар хавсралтаар батлагдсан **хариу өгөх мэдэгдлийн** маягтаар болон **утсаар** хариуг өгдөг.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх 1 дүгээр улирлын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр, хагас жилийн тайланг 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 2/259 дугаар албан бичгээр, 3 дугаар улирлын тайланг 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 3/384 дугаар албан бичгээр аймгийн ЗДТГ-ын ТЗУХэлтэст тус тус хүргүүлсэн.







2019 оны 3 дугаар улирлын байдлаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо | Шийдвэрлэсэн: Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн | Хугацаа болоогүй | Шийдвэрлэлт /хувь/% |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | 154 | 112 | - | 5 | 38 | 73 |

Хүснэгт № 2

2019 оны 3 дугаар улирлын байдлаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл /хэлбэрээр/

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо | Үүнээс: Бичгээр | Цахим хэлбэрээр | Утсаар | Биечлэн уулзсан | Бусад |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | 154 | 150 | - | 4 | - | - |

Дээрх тайланг байгууллагын цахим хуудас /www.dundgovi.gazar.gov.mn/-ны үйл ажиллагааны ил тод байдал хэсэгт тухай бүр байршуулан мэдээллийг шинэчилсэн.




2018 оны өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд байгууллагын дарга Э.Чагнаадорж танилцуулга мэдээлэл хийсэн.



2019 оны жилийн эцсийн байдлаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

Хүснэгт № 1

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо | Шийдвэрлэлт | | | | Шийдвэрлэл-тийн /%/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн | Хугацаа болоогүй | |
| 1 | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | 232 | 203 | - | 5 | 29 | 88 |

Хүснэгт № 2

2019 оны жилийн эцсийн байдлаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл /хэлбэрээр/

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Бичгээр | Цахим хэлбэрээр | Утсаар | Биечлэн уулзсан | Бусад |
| 1. | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | 232 | 228 | - | 4 | - | - |

2019 оны жилийн эцсийн байдлаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл /агуулгаар/

| | | |
|---|---|---|
| 1. | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | Нийт өргөдлөөс: 232<br><br>Хүсэлт 30/13%<br>Өргөдөл 198/85%<br>Санал 2/0.8%<br><br>Гомдол 2/1%<br><br>• Барилгын асуудлаар 28/12%<br>• Газар эзэмших, өмчлөхтэй холбоотой 56/24%<br>• Газрын маргааны асуудлаар 12/5%<br>• Газар эзэмших гэрээ сунгуулах асуудлаар 2/0,8%<br>• Газрын хэмжээ өөрчлөхтэй холбоотой 47/21%<br>• Газар эзэмших эрх шилжүүлэхтэй холбоотой 36/16%<br>• Газар эзэмших гэрчилгээ нөхөн авах, шинэчлүүлэх 12/9%<br>• Ажлаас чөлөөлөгдөх тухай 1/0,5%<br>• Зориулалт өөрчлөх 7/3%<br>• Тайлбар, хүсэлт 30/13%<br>Иргэдээс 228 санал, өргөдөл, гомдол бичгээр, 4 санал, гомдол 7059106 утсанд ирүүлсний 198өргөдөл гомдлыг буюу 85 хувийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. 5 өргөдлийг хугацаа хэтэрч шийдвэрлэсэн байна. 29 өргөдлийн хуулийн хугацаа болоогүй ба судалгааны шатанд байна. Тус байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан санал, өргөдөл, гомдлын нийт 30 буюу 13 хувь нь хүсэлт, 198 буюу 85 хувийг өргөдөл эзэлж байгаа ба өргөдөл давамгайлсан бүтэцтэй байна. Иргэдээс ирүүлсн өргөдөл гомдлын дийлэнх хувийг газрын хэмжээ өөрчлүүлэх, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл, шинээр газар эзэмших тухай өргөдлүүд эзэлж байна.<br>Өргөдлийн хариуг ГХГЗЗГ-ын даргын 2008 оны 133 дугаар тушаалын 08 дугаар хавсралтаар батлагдсан хариу өгөх мэдэгдэл болон утсаар өгч хэвшсэн. |

Тайлан гаргасан:

ГАЗРЫН ТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭ, ТАТВАРЫН
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Д.БОЛОРЧИМЭГ

Хянасан:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Б.РЭНЦЭНДОРЖ